

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэлд:

ҮҮ.ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлд тавигдсан хатуу хучилттай авто замын хураамжийг бууруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгав.

2. Дараахь арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд даалгав:

2.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Чалко Трэйдинг Хонконг” ХХК-ийн хооронд байгуулсан “Нүүрс худалдах, худалдан авах тухай гэрээ” хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийг хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх;

2.2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-д зориулалтын бус, ашиглалтын шаардлага хангаагүй хүнд даацын автомашин болон дугуй нийлүүлсэн асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж, компанид учирсан хохирлыг арилгуулах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР